



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

“Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалт, компанийн дүрмийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2019 оны 05/3931 дүгээр дүгнэлтийг харгалзан “Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Б.Гүнболд /Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/, Ж.Батсуурь /Барилга, хот байгуулалтын яамны харьяа Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга/, Ц.Зоригтбат /Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга/, С.Энхцэцэг /Улсын Их Хурлын Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны Ажлын албаны референт/, Ц.Батзул /Сангийн яамны Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга/, Ц.Баяр-Эрдэнэ /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга/, Б.Сүнжидмаа /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн мэргэжилтэн/ нарыг томилсугай.


2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД



0000395